БАТЛАВ:
СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, ЗАЛУУЧУУДЫН ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
С.ОЮУНБИЛЭГ

АТА12931 6594204 9024070543

ЗҮҮН БҮСЭД ТҮҮХ, СОЁЛЫН НӨӨЦӨД ТҮШИГЛЭСЭН БУЙР НУУР ОРЧМЫН БОЛОН ХИЛ ДАМНАСАН АЯЛЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ТУСГАЙ БҮСИЙН ТЕХНИК ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДЭСЛЭЛ БОЛОВСРУУЛАХ ТЕНДЕРИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭГЧИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ АЖЛЫН ДААЛГАВАР

2025 оны 04 дүгээр сарын 07-ны өдөр Улаанбаатар хот

1.	Үндэслэл:	Монгол Улсын Их Хурал (УИХ)-ын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “Алсын хараа 2050” урт хугацааны бодлогын баримт бичгийн зорилт: - 4.2.46. “Зарим тусгай хамгаалалттай газар нутгийг байгальд ээлтэй эко аялал жуулчлалын зориулалтаар төлөвлөн хөгжүүлнэ.”, - 8.2-т “Эдийн засгийн тэргүүлэх салбарууд болон байршлын давуу талд тулгуурлан бүс, орон нутагт аялал жуулчлалыг хөгжүүлнэ”, - 8.2.4. Дорнод аймагт Халх гол, Буйр нуур, хил орчмын аялал жуулчлалыг дэмжинэ.”, - 8.2.5. Хэнтий аймагт Монголын төрт ёсны түүх, дурсгалын үнэт өв, нүүдлийн соёл, уламжлалт ахуйд түшиглэн “Чингис хаан аялал жуулчлалын цогцолбор” байгуулна.”, - 8.2.6. Сүхбаатар аймагт түүх соёлын өвд түшиглэсэн хил орчмын аялал жуулчлалыг дэмжинэ гэж, Монгол Улсын Их Хурлын 2024 оны 64 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Монгол улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”-ын 3.5.1. “Зүүн бүсэд түүх, соёлын нөөц, экосистемд түшиглэсэн хил орчмын болон хил дамнасан аяллыг хөгжүүлж, аялал жуулчлалын тусгай бүсийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд байгуулна.” гэж, Аялал жуулчлалын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1. “Монгол Улс тодорхой газар нутгийг тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх, гадаадын болон дотоодын хөрөнгө оруулалтыг татах, аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг төрөлжүүлэн хөгжүүлэх зорилгоор орон зайн зохистой төлөвлөлтийг бий болгосон аялал жуулчлалын бүстэй байна.” гэж, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.3.6.1.Зүүн бүсийг түүхэн аялал жуулчлалын төрөлжсөн бүс болгон хөгжүүлэх хүрээнд Бурхан халдун, Дэлүүн болдог, Буйр нуур, Халх гол, Алтан овоо, түүхэн

		аялал жуулчлалын газар нутгийг дэд бүтцээр холбох, усан боомт болон олон улсын 4С нисэх буудал байгуулна.
2.	Зорилго:	Зүүн бүсийн Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймгийн байгаль, түүх, соёлын нөөцөд тулгуурлан түүхэн аялал жуулчлалыг хөгжүүлэх, улсын аялал жуулчлалын бүс тогтоож, аялал жуулчлалын бүтээн байгуулалтыг төлөвлөх, Буйр нуур орчмын бүс нутгийн байгаль газарзүй, нийгэм эдийн засгийн нөхцөл байдлыг үнэлэн, аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор улсын тусгай бүсийг тогтоож, төлөвлөлт хийх үндэслэлийг боловсруулах
3.	Байршил:	Буйр нуур, Дорнод аймгийн Халх гол сум
4.	Хамрах хүрээ:	Зүүн бүсийн 3 аймаг буюу **Хэнтий, Дорнод, Сүхбаатар** аймаг, Буйр нуур орчмын бүс нутгийн судалгаа, аялал жуулчлалын төлөвлөлт
5.	Ашиглах материал	Хууль, дүрэм, журам: - Монгол Улсын Үндсэн хууль - Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль; - Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай хууль; - Соёлын өвийг хамгаалах тухай хууль; - Аялал жуулчлалын тухай хууль; - Ашигт малтмалын тухай хууль; - Автозамын тухай хууль; - Байгалийн ургамлын тухай хууль; - Ойн тухай хууль; - Усны тухай хууль; - Хамгаалалтын бүс тогтоох тухай; - Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль; - Хот суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хууль; - Барилгын тухай хууль; - Монгол Улсын Инновацийн тухай хууль; - Байгаль орчинд нөлөөлөх байдлын тухай; - Байгаль орчныг хамгаалах тухай хууль; - Байгалийн ургамлын тухай хууль /нэн ховор, ховор ургамлын жагсаалт/, - Амьтны тухай хууль - Гамшгаас хамгаалах тухай хууль; - Галын аюулгүй байдлын тухай хууль; - Газрын тухай хууль; - Харилцаа холбооны тухай хууль; - Хөрс хамгаалах тухай хууль; - Газрын хэвлийн тухай хууль; - Эрчим хүчний тухай хууль; - Эрчим хүчний хэмнэлтийн тухай хууль; - Бусад хуулиуд; Бусад: - Байгаль хамгаалах олон улсын холбоо /IUCN/-аас гаргасан Тусгай хамгаалалттай газар нутгийн аялал жуулчлал ба аялагчдын удирдлага, зохион байгуулалт "Тогтвортой хөгжлийн удирдамж" гарын авлага, 2020 он; Бусад холбогдох дүрэм журам, стандарт, баримт бичиг, Норм, нормативууд

6.	Хийгдэх ажил	Зүүн бүсэд түүх, соёлын нөөцөд түшиглэсэн Буйр нуур орчмын болон хил дамнасан аяллыг хөгжүүлэх, аялал жуулчлалын тусгай бүсийн техник эдийн засгийн үндэслэл боловсруулах ба дараах асуудлыг шийдвэрлэнэ. **1. Аялал жуулчлалын нөөц даацыг тодорхойлж, үнэлгээ хийх** - Аялал жуулчлалын нөөц, даацын судалгаа хийж, аялал жуулчлалын голлох бүтээгдэхүүн үйлчилгээний өнөөгийн нөхцөл байдлыг тодорхойлох - Түүх соёлын өвийн нөөцийг тоймлож, хууль эрх зүйн хүрээнд хадгалах, хамгаалах, ашиглах арга аргачлалыг тодорхойлох - Археологийн нөөцийг аялал жуулчлалын эргэлтэд оруулах боломжийг тодорхойлох - Байгаль орчны хүчин зүйлийн үнэлгээ хийж, Буйр нуурын эко бүс болон амьтан ургамлын тархцад үзүүлэх эерэг, сөрөг нөлөөг тооцох - Ашигт малтмал, уул уурхайн төлөвлөлт, олголтын судалгаа хийж, давхацлыг тодорхойлох - Олон улсын хамгаалалттай бүсүүдийн төлөвлөлт, хамгаалсан байдлын судалгаа хийж, бүсийн давхацлыг тодорхойлох - УТХГН-ын сүлжээний нөхцөл байдлыг тодорхойлж, давхацлыг тодорхойлох - Нийгэм, эдийн засгийн хүчин зүйлийн үнэлгээ хийж, бүс нутгийн хөгжилд оролцогч талуудын хамтран ажиллах сонирхлыг тогтоох - Эрэлт, нийлүүлэлтийн шинжилгээ хийх - Аялал жуулчлалын дэд бүтэц, тээвэр логистикийн нэгдсэн сүлжээ, боомт, чөлөөт бүс, тусгай бүсийг хөгжүүлэх боломжийг тодорхойлох - Гадаад, дотоодын нийт зорчигчдын тоо, жилд үйлчлэх жуулчдын эрэлт, нийлүүлэлтийн хүчин чадлыг судалж, төлөвлөлтийн шийдэл гаргах - Зүүн бүс, Буйр нуур, нуур орчмын рекреацын үнэлгээг хийх - Бүс нутгийн нийгэм, эдийн засгийн үндсэн үзүүлэлтийн харьцуулсан судалгаа хийх - Бодлогын баримт бичигт дүн шинжилгээ хийх - Олон улсын туршлага, чиг хандлагын судалгаа хийх - Аялал жуулчлалын зорих газрын орон зайн дүн шинжилгээ хүчин зүйлийн үнэлгээ хийх - Буйр нуур орчимд усан аялал жуулчлалыг хөгжүүлэх боломжийн талаар судалгаа хийнэ - Зүүн бүсийн болон Буйр нуур орчмын аялал жуулчлалын SWOT, TOWS, PESTLE шинжилгээг хийх **2. Аялал жуулчлалын орон зайг тодорхойлох**

		- Монгол улсын Засгийн газрын болон аймаг, орон нутгийн бодлого, төлөвлөлтийг үндэслэн урт, дунд хугацааны хөтөлбөр, төлөвлөгөөтэй уялдааг хангах - Нийгэм эдийн засгийн хүчин зүйлийг тодорхойлж аймаг, орон нутгийн хүн амын орлогыг нэмэгдүүлэхэд чиглэх - Аймаг, орон нутгийн аялал жуулчлалын эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэхэд чиглэх - Тухайн бүс нутаг орчмын аялал жуулчлалын орон зайн төлөвлөлтөд отоглох цэгүүд, эко аяллын бүс, хамгаалах шаардлагатай бүс, бүсчлэлийг тодорхойлох - Нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалын менежментийн тогтолцоо, сайн туршлагыг тодорхойлсон зөвлөмж боловсруулах - Буйр нуур орчимд аялал жуулчлалын кластер хөгжил, бүс нутгийн таталцлыг тодорхойлох - Тухайн бүсийн аялал жуулчлалыг орон нутгийн онцлогт тулгуурлан улсын жишиг хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн, эдийн засгийн тэргүүлэх салбарын нэг болох олон улсад өрсөлдөх чадварыг дээшлүүлэх тогтвортой аялал жуулчлалыг тодорхойлж үнэт зүйл, давуу тал, онцлогийг илэрхийлсэн алсын хараг боловсруулах - Улсын болон орон нутгийн аялал жуулчлалын бүсийг тодорхойлох - Монгол Улс болон бүс нутгийн хэмжээнд тухайн төслийн үзүүлэх нөлөөлөл, хөгжүүлэх зорилгыг тодорхойлох - Аялал жуулчлалын бүсийг хөгжүүлэх зорилтуудыг судалгааны шатанд тодорхойлж гаргах - Түүх соёл, байгалийн өвөрмөц тогтоц бүхий газрыг түшиглэсэн амралт жуулчлалын бүс, аялал жуулчлалын тэргүүлэх чиглэлийг тодорхойлох - Буйр нуур орчмын болон дайран өнгөрөх аялал жуулчлалын төрлийг тодорхойлж маршрут гаргах - Амралт, бааз, отоглох цэгийн үйл ажиллагаа, нуурын хамгаалалт, эрүүл ахуй, хог хаягдлын болон хөрсний бохирдлоос сэргийлэх менежментийн зөвлөмжийг боловсруулах - Аялал жуулчлалын дэд бүтцийг бүрдүүлэх, хөгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулах - Төслийн судалгаанд үндэслэн зам дагасан үйлчилгээний барилга байгууламжийн шаардагдах хүчин чадлыг тодорхойлж концепц, загвар зураг боловсруулах - Төслийн хүрээнд нутгийн иргэдийн олон нийтийн арга хэмжээ зохион байгуулах барилгын хүчин чадлыг тодорхойлж концепц загвар зураг боловсруулах **3. Аялал жуулчлалын тусгай бүсийн хөгжлийн нийтлэг концепцийг боловсруулж, цаашид хөгжүүлэх бодлого, чиглэлийг тодорхойлно.**

		- Түүхэн болон байгаль, соёлын нөөцөд түшиглэсэн аялал жуулчлалыг хөгжүүлэх - Хил орчмын болон хил дамнасан аяллыг хөгжүүлэх чиглэлээр үндэслэл бүхий хөгжлийн үзэл баримтлалын санал боловсруулна. **4. Төлөвлөлтийн чиглэлээр:** - Монгол улсын Засгийн газрын болон аймаг, орон нутгийн бодлого, төлөвлөлтийг үндэслэн зүүн бүсийн аялал жуулчлалын үзэл баримтлалыг тодорхойлж, бүс нутгийн хөгжлийн орчин үеийн чиг хандлагыг тодорхойлох - Бүс нутгийн онцлог, давуу талыг нээн илрүүлж, байгалийн нөөц баялгийг зохистой, өгөөжтэй, хүртээмжтэй ашиглан, эдийн засгийн чиг үүргийг оновчтой тодорхойлох - Үйлдвэр, үйлчилгээг кластерын бодлогоор дэмжиж, бүс дамнасан, салбар хоорондын уялдааг хангах, - Бүс нутгийн хөгжилд оролцогч талуудын хамтран ажиллах сонирхлыг тодорхойлон, хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, ажилгүйдэл ядуурлыг бууруулах боломж, орон нутагт ажиллаж, амьдрах, бизнес эрхлэх таатай нөхцөлийг бүрдүүлэх - Тээвэр логистикийн нэгдсэн сүлжээ, боомт, чөлөөт бүс, тусгай бүсийг хөгжүүлэх - Бүсийн орон зайн төлөвлөлтийн хувилбаруудын саналыг боловсруулан тохиромжтой хувилбарыг сонгох **5. Төлөвлөлтийн хүчин чадлын хувилбарууд:** - Цогцолборын хүчин чадлын урьдчилсан тооцоолох - Хэтийн төлөв төсөөлөл, таамаглалыг тооцоолох - Төслийн үйлчлүүлэгчдийн ерөнхий тооцоо - Төслийн үйлчлүүлэгчдийн хөдөлгөөний урсгалын тооцоо - Төслийн барилга, байгууламжийн суурилагдах хүчин чадлын тооцоо - Орон зайн төлөвлөлтийн санал - Зам тээврийн сүлжээ - Ажиллах хүчний тооцоо - Инженерийн дэд бүтцийн шийдэл гаргах - Бүтээн байгуулалт, санхүүжилт, хөрөнгө оруулалтын томсгосон тооцоолол - Бүтээн байгуулалтын үе шат, удирдлага - Хөрөнгө оруулалт, санхүүжилт - Төслийн орлогын урчилсан төсөөлөл - Эрсдэлийн үнэлгээ, удирдлага **Дүгнэлт, зөвлөмж**
7.	Үйлчилгээ үзүүлэх этгээдэд тавигдах шаардлага	**Зөвлөх үйлчилгээ үзүүлэх этгээд нь судалгаа, төлөвлөлт, төсөл хөтөлбөр, зөвлөх үйлчилгээ, үнэлгээний үйл ажиллагаа явуулж байсан туршлагатай байна. Үүнд:**

		Аялал жуулчлалын болон бүс орон нутгийн хөгжлийн чиглэлээр судалгаа, зөвлөх үйлчилгээ, бодлогын судалгааны ажил, ТЭЗҮ боловсруулж байсан туршлагатай байх - Тухайн байгууллагын санал болгож буй зөвлөхүүд нь аялал жуулчлал, бүс орон нутгийн хөгжлийн чиглэлээр судалгаа хийж байсан, тухайн чиглэлээр төрийн бодлого боловсруулах ажилд оролцож ТЭЗҮ боловсруулж байсан туршлагатай байх бөгөөд сүүлийн 5 жилийн хугацаанд дээрх чиглэлээр 10 болон түүнээс дээш тооны ажлын зураг эсвэл загвар зураг, концепц төслийн ажлыг гүйцэтгэсэн туршлагатай байх **Хуулийн этгээд болон хувь хүн нь дараах голлох мэргэжилтнүүдээс бүрдэх багийг ажиллуулах ба зөвлөх үйлчилгээг гүйцэтгэхэд шаардлагатай бусад хүний нөөцийг бүрдүүлсэн байна. Үүнд:** **Багийн ахлагч:** **Архитектор нь:** - Архитектор мэргэжилтэй байх бөгөөд хот төлөвлөлт, эзлэхүүн төлөвлөлтийн мэргэшсэн зэрэгтэй эсвэл түүнээс дээш зэрэгтэй байх - Аялал жуулчлалын чиглэлээр судалгаа шинжилгээний ажил хийж байсан туршлагатай байх - Олон улсын байгууллагатай хамтран аялал жуулчлалын чиглэлээр ТЭЗҮ, зураг төслийн ажил хийж байсан туршлагатай байх - Аялал жуулчлалын чиглэлээр 5-аас цөөнгүй томоохон зураг төсөл, ТЭЗҮ боловсруулж байсан туршлагатай байх - Улсын зэрэглэлтэй уралдаанд оролцож 3-аас доошгүй удаа амжилт үзүүлсэн туршлагатай байх - Бодлогын бичиг баримтад боловсруулж байсан туршлагатай байх - **Гишүүд:** **Аялал жуулчлалын судлаач – Зөвлөх** - Аялал жуулчлал, бүс нутаг хөгжлийн төлөвлөлтийн чиглэлээр магистр эсвэл доктор зэрэгтэй байх - Аялал жуулчлалын болон олон улсын төсөл хөтөлбөрт 10 болон түүнээс дээш жил ажилласан туршлагатай байх - Аялал жуулчлалын бодлого төлөвлөлтийн чиглэлээр ажиллаж байсан туршлагатай байх **Хот төлөвлөлтийн судлаач – Зөвлөх** - Хот төлөвлөлт эсвэл эзлэхүүн төлөвлөлтийн зөвлөх зэрэгтэй байх - Хот төлөвлөлт хяналт шинжилгээ үнэлгээний чиглэлээр 15 болон түүнээс дээш жил ажилласан туршлагатай байх

		- Төрийн бодлого стратеги хууль тогтоомжийн хяналт шинжилгээ, үнэлгээний чиглэлээр ажиллаж байсан туршлагатай **Археологич – Зөвлөх** - Археологич доктор зэрэгтэй байх - Шинэ олдвор бүтээл нээн илрүүлсэн олон улсад үнэлэгдсэн туршлагатай байх - Мэргэжлээрээ 10 ба түүнээс дээш ажилласан туршлагатай байх - Тухайн чиглэлээр ном товхимол 3 -аас цөөнгүй хэвлүүлэн нийтлүүлсэн туршлагатай байх - Бүс нутаг, хот төлөвлөлтийн чиглэлээр төсөл хөтөлбөрт оролцож байсан туршлагатай байх **Түүх, соёл судлаач нь:** - Мэргэшсэн зэрэгтэй байх - Бодлогын бичиг баримтад оролцож байсан туршлагатай - ТЭЗҮ боловсруулж байсан туршлагатай байх бөгөөд 10 ба түүнээс дээш ажилласан жилийн туршлагатай байх **Эдийн засагч нь:** - Мэргэшсэн ба түүнээс дээш зэрэгтэй байх - Бодлогын бичиг баримтад оролцож байсан туршлагатай - ТЭЗҮ ажилд 10 ба түүнээс дээш төсөл хөтөлбөрт оролцож байсан туршлагатай байх - Аялал жуулчлалын төсөлд оролцож байсан туршлагатай байх **Газарзүйн мэдээллийн системийн мэргэжилтэн нь:** - Мэргэшсэн зэрэгтэй байх - Мэргэжлээрээ 5 ба түүнээс дээш ажилласан туршлагатай байх **Байгаль орчин экологийн мэргэжилтэн нь:** - Мэргэшсэн зэрэгтэй байх - Мэргэжлээрээ 5 ба түүнээс дээш ажилласан туршлагатай байх **Газар зохион байгуулагч нь:** - Мэргэшсэн зэрэгтэй байх - Мэргэжлээрээ 5 ба түүнээс дээш ажилласан туршлагатай байх
8.	Баримт бичгийн иж бүрдэл:	**Судалгаа, үнэлгээ тооцооллын аргачлал арга зүй**; - Материалд дүн шинжилгээ боловсруулах - Судалгааны үр дүнгийн нэгтгэл боловсруулах - Орон нутгийн иргэд, оршин суугчид, төлөвлөлтийн бүсэд хийгдсэн олон нийтийн судалгаа - Хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, хөрөнгө оруулалтын тооцоо хийх - Бусад шаардлагатай материалын судалгаа дүгнэлт - Төлөвлөлтийн талаарх танилцуулга - Загвар зургийг орон нутгийн эрх бүхий байгууллагатай зөвшилцөн батлуулах - Аннимэшн хийх 2-3 минут **Зураглалын бүрдэл:** Судалгаа, үнэлгээ тооцооллын зураглал: /*Машстаб сонголтоор*/ - Зургийн жагсаалт, тайлбар бичиг

		- Зорих газрын аяллын маршрут - Байршлын схем - Орчны тойм - Авто зам тээврийн сүлжээ - Барилгажилт - Газар ашиглалтын судалгаа - Газар ашиглалтын бүсчлэл - Түүх соёл, аялал жуулчлал - Нийгэм Эдийн засгийн үнэлгээ - Дэд бүтцийн үнэлгээ - Архитектур, түүх, соёл, археологийн дурсгал **Концепц, загвар зургийн төлөвлөлтийн зураглал**: */Машстаб сонголтоор/* - Зургийн жагсаалт, тайлбар бичиг - Газрын нэгдмэл сангийн ангилал - Гудамж, замын сүлжээ - Цогцолбр барилгын ерөнхий төлөвлөгөөний бүсчлэл - Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө - Архитектур орон зайн төлөвлөлт, барилгажилт - Газар зохион байгуулалтын төлөвлөлт - Ногоон байгууламж, спорт, амралт, аялал зугаалгын бүс - Соёл, ахуй үйлчилгээний ангилал, үйлчлэх хүрээ - Аялал жуулчлалын менежмент нэгдсэн төлөвлөлт - Тусгай хамгаалалттай бүс хориглох, хязгаарлах дэглэмтэй бүсүүдийн төлөвлөлт - Дугуйн зам, хөсөг тэрэг, явган зам .... гм аяллын төлөвлөлт - Нийтийн тээврийн нэгдсэн зогсоол, авто машины зогсоол, төлөвлөлт - Төлөвлөлтийн үе шатны зураглал - Төлөвлөлтийн хүрээнд шинээр дахин төлөвлөх, сэргээн засварлах, хамгаалалтад авах бүс - Ерөнхий харагдах байдал /3D зураг/ **Тоон материалын бүрдэл:** - Тайлбар бичиг /*.doc, *.pdf/ - Товч танилцуулга 25-35 хуудаснаас ихгүй слайд байх/*.ppt/ - Төлөвлөлтийн онцлогийг харуулсан анимэйшн 2 минутаас багагүй байх /*.mp4 / - Ажлын үе шатны зураглалын бүрдэл /*.dwg, *.pdf, *.jpg/ - Загвар зургийг /концепц/ орон нутгийн эрх бүхий байгууллагатай зөвшилцөн баталгаажуулсан байх - Хот байгуулалтын иж бүрэн үнэлгээ
9.	Ажлын үе шатанд тавигдах шаардлага:	- Буйр нуурын бүсэд экологийн тэнцвэрт байдал, нөөц баялгийг хадгалан авч үлдэх, байгаль орчны онцгой хамгаалалтын бүсүүдийг тогтоох, түүх соёлын дурсгалыг хамгаалах, эрүүл ахуй, галын аюулгүйн шаардлагыг хангах хамгаалах арга замыг тусгах; - Тухайн нутаг дэвсгэрт ажиллаж, амьдарч буй иргэдээс төлөвлөлтөд тусгах зорилгоор санал асуулга, судалгаа явуулсан байх; - Аялал жуулчлалын маршрут, дэд бүтцийн хангамжийг шийдвэрлэх, төлөвлөлт хийхдээ мэргэжлийн байгууллагуудтай зөвшилцөх, урьдчилсан байдлаар санал авсан байх шаардлагатай; - Концепц, загвар зураг төслийг эхний ээлжийн сонгосон байршилд боловсруулах;

		- Шинээр боловсруулах концепц, загвар зураг төслийг өмнө нь хийгдэж байсан бодлогын бичиг баримттай уялдуулан шийдэл гаргах; - Загвар зургийг (концепц) орон нутгийн эрх бүхий байгууллагатай зөвшилцөн баталгаажуулсан байх - Төлөвлөлтийн онцлогийг харуулсан анимэйшн 2 минутаас багагүй байх - Авто болон явган аялагчийн нэвтрэх хаалтыг хийхдээ олон улсын жишигт нийцсэн шийдлүүдээс боломжит хувилбарыг сонгох, нэвтрэх хураамжийн төлбөрийг ухаалаг системээр шийдэх арга зам, аргачлалыг гаргах. - Нэн ховор, ховор амьтан, ургамлын тойм судалгаа хийж, аяллын маршрутад оруулах холбогдох эрдэм шинжилгээний байгууллагатай зөвшилцөн ажиллах; - Аяллын маршрутыг ховор амьтан, ургамлын нягтшил бага газраар төлөвлөх; - Олон улсын стандартын дагуу явган аяллын маршрутыг байгальд ээлтэй байдлаар төлөвлөх; - Судалгааны дагуу гарсан материалыг ашиглан мэдээ, мэдээллийн самбаруудад тусгах мэдээллийн бүрэлдэхүүнийг тодорхойлж самбарын жишиг загвар төлөвлөх; - Төслийн техник эдийн засгийн үндэслэлийг тодорхойлсон тайлбар бичиг 3 хувь цаасан хувилбар, файл хэлбэрээр тус тус ирүүлсэн байна.
10	Боловсруулах хугацаа, тайлангийн бүрдэл:	**Захиалагч, гүйцэтгэгч талуудын хооронд байгуулсан гэрээгээр гүйцэтгэх хугацааг үндэслэл болгоно.** **Эхлэлийн тайлан: 45 хоног** - Одоогийн байдлын судалгаа, аялал жуулчлалын нөөц даацыг тодорхойлох судалгаа боловсруулсан байх. Одоогийн байдлын үнэлгээ дүгнэлт хийж аялал жуулчлалын бүс нутгийн ерөнхий тооцоолол концепц санал боловсруулна. (Ai ашиглах боломжтой) **Дундын тайлан: 90 хоног** - Эхлэлийн тайланд өгсөн санал зөвлөмжийг тусгаж тавигдах шаардлагын дагуу концепц, загвар зураг боловсруулан орон нутгийн иргэдэд танилцуулах - Мэргэжлийн байгууллага болон Төр захиргааны байгууллагуудад танилцуулан санал асуулга зохион байгуулах

		- Сонгосон эхний ээлжийн байршилд байгаль орчны нөхцөл байдлын ерөнхий дүгнэлтийг өмнө нь судлагдсан бичиг баримтад үндэслэн дүгнэлт гаргах - Геологи хөрсний шинж байдлын талаар өмнө нь судлагдсан бичиг баримтад үндэслэн ерөнхий дүгнэлт гаргах. - Сонгосон байршилд шаардлагатай тохиолдолд зөвхөн цогцолбор барилгын дэвсгэр зураг хийх **Эцсийн тайлан: 45 хоног** - Аялал жуулчлалын маршрут, зорих газруудыг тодорхойлон сонгосон байршилд эхний ээлжийн барилгын концепц, загвар зураг боловсруулан холбогдох Төр захиргааны байгуулгаатай зөвшилцөн хэлэлцүүлэг хийх
11	Захиалагч байгууллага	Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам
12	Зөвшөөрөлцөх байгууллага	Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэн УТҮГ Орон нутгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар